

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/123/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: [Sunjidmaae@audit.gov.mn](mailto:Sunjidmaae@audit.gov.mn)



ЕСӨНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН  
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГАН БҮРЭНЧӨДӨР ТАНАА

## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 111

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Сөрөг санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар авлага өглөгийн тооцоо нийлээгүй, барагдуулах арга хэмжээ авдаггүй, нярвын тайлан гаргаагүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, түлээ нүүрсний хөнгөлөлтөөс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, цалингийн зардлаас олон нийтийн цагдаагийн цалин олгож зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, ажилтнуудад цалинг илүү тооцож олгосон, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зардлыг олгохдоо анхан шатын баримтад үндэслээгүй, санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын өр авлагыг тайлагнаагүй, шилэн дансны мэдээлэл хангалтгүй оруулсан, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, давтан гаргасан зэрэг 212,618.0 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 57 дугаар зүйлийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4, 6 дугаар зүйлийн 6.3.2, 16 дугаар 16.5.7 заалт, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын 3 дугаар 3.7, заалт, хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 14 дүгээр зүйлийн 14.1, 17 дугаар 17.1,1 заалт, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн

0702900332

тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас аймгийн Цагдаагийн газарт компьютер, иж бүрэн камер худалдан авч өгсөн байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг төсвийн хэлбэлзлийн тайлангийн дүнгээр шивж бэлтгэсэн байна.

### **Бусад асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, жилийн эцсийн иргэдийн Төлөөгчдийн Хуралдаанаар тайлангаа хэлэлцүүлэн хангалттай дүгнэгдсэн

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	4,168.7	11,123.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	26,684.4	13,679.1
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>30,853.1</b>	<b>24,802.6</b>
Нийт өр төлбөрийн дүн	316.3	155.1
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	30,536.8	24,647.5
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>30,583.1</b>	<b>24,802.6</b>
Үйл ажиллагааны орлогын дүн	209,250.0	227,102.7
Үйл ажиллагааны зардлын дүн	197,641.1	226,706.2
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>11,608.9</b>	<b>396.5</b>
Үйл ажиллагааны бус үр дүн		
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>11,608.9</b>	<b>396.5</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,927.8	24,250.9
Тайлант оны үр дүн	11,608.9	396.5
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>30,583.1</b>	<b>24,647.5</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	209,250.0	227,102.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	209,205.0	221,752.8
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>		<b>5,350.0</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>		<b>5,350.0</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>		
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>-5,350.0</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>		
Урсгал зардал	201,872.0	223,802.8
Хөрөнгийн зардал	200,437.2	219,951.1
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>		
Улсын төсвөөс санхүүжих		
Орон нутгийн төсвөөс санхүүжих	201,872.0	223,802.8

Гурав. Аудитын илрүүлэлт:

**Аудитын илрүүлэлт**

Залруулагдаагүй нийт 212.618.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их аудитын хангалттай ба зохистой нотолгоог хангалтгүй, санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл өндөр тул “Сөрөг” санал дүгнэлт өгсөн

Аудитаар нийт 212.618.0 мянган төгрөгийн 14 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1,266.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 211.351.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байх талаар 11 албан шаардлага, 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

1. Түлээ нүүрсний хөнгөлөлтөөс ХХОАТ 50.5 мянган төгрөгийг суутган тооцоогүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т "ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого"; 14 дүгээр зүйлийн 14.1.-т "Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу суутгасан татварыг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

2. Ажилтнуудад 1,216.1 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно"

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалинг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

### 5.2 Албан шаардлага

1. Жилээс дээш насжилттай 7,784.9 мянган төгрөгийн авлагын тооцоо нийлээгүй, НДШ авлагыг 5,150.5 мянган төгрөг, удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтны шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговор 3,940.8 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Авлагыг тооцоо нийлж баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд тайлагнаж байх албан шаардлага хүргүүллээ.

2. Өглөгийг 135.1 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Өглөгийн тооцоо нийлж баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд тайлагнаж байх албан шаардлага хүргүүлээ.

3. Цалингийн зардал, нийгмийн даатгалд тайлагнасан цалингийн дүнгээс 4,134.4 мянган төгрөгөөр, Татварын хэлтэс, нийгмийн даатгалд тайлагнасан цалин 16,602.5 мянган төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх;" 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах/- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Татвар, нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнан зөрчлийг арилгаж, зөрчлийг арилгаж албан шаардлага хүргүүлээ.

4. Няравын тайлан гаргаагүй, бараа материалын тайланд бичиг хэргийн зардал 450.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлыг 1,250.0 мянган төгрөгөөр шууд бичилтээр тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 14 дүгээр зүйлийн 14.1-т "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно". 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"-гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

5. Зарцуулалт тодорхойгүй, анхан шатны баримт хангалтгүй 24,674.0 мянган төгрөгөөр гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 14 дүгээр зүйлийн 14.1-т "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно". 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас

баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"-гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

6. Нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй 42,071.0 мянган төгрөг төгрөгийн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хийсэн гэх боловч тушаал, илтгэх хуудас, тооцоо бодсон баримтаар нотлогдохгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Хөрөнгийн тооллогын холбогдох хууль, журмын дагуу хийж илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

7. Багийн иргэдийн нийтийн хурлын даргалагч нарт 1,100.0 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон бөгөөд нийгмийн даатгал шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14.1.-т "Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө": 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх"- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Нийгмийн даатгалын шимтгэл, татварын нөхөн тайлагнан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

8. Цалингийн зардлаас олон нийтийн цагдаагийн 7,607.2 мянган төгрөгийн цалин олгож зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, бүлэг хооронд гүйлгээ хийхгүй байх албан шаардлага хүргүүлсэн

9. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал 15,120.0 мянган төгрөгийг олгохдоо тайлан, санхүүгийн баримтад үндэслээгүй нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.7-т "Төлөөлөгчийн үйл ажиллагаа, чадавхжуулах арга хэмжээнд шаардагдах зардлын төсвийг сар, улирлаар хуваарилах бөгөөд урьд олгогдсон төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн баримт, тайланг бүрэн гаргасны дараа төлөөлөгчийн бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дараагийн сар, улирлын төсөвт

зардлыг тухай бүр олгоно” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төлөөлөгчийн зардлыг анхан шатны баримтад тулгуурлан зарцуулах албан шаардлага хүргүүлсэн

10. Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн орлогыг 1096.2 мянган төгрөгөөр дутуу, нэмэлт санхүүжилтийн тайланд 90.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, санхүүжилтээс татан төвлөрүүлсэн 3,851.6 мянган төгрөгийг хасах дүнгээр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-т "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5.бүх орлого; Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын хавсралтын 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого, түүний зарцуулалтыг сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын явцын мэдээнд оруулж, тухайн тайлант оны санхүүгийн болон үр дүнгийн тайланд тусгана",- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлаг үнэн зөв тайлагнаж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

11. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2023 оны 01/104-06/104 дугаартай төлбөрийн акт, 01/141-10/141 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй, уг зөрчлийг давтан гаргасан.

Санхүүгийн тайлангийн аудитаар цалин илүү тооцож олгосон, өглөг авлагын тооцоо нийлээгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажиллагааны зардлыг шилжүүлэхдээ анхан шатны баримтад үндэслээгүй, 1-6 сарын гүйлгээ баланс байхгүй, шууд бичилтээр тайлагнасан, бүлэг хооронд гүйлгэн зарцуулдаг, и баримтгүй гүйлгээ хийсэн, урамшууллаас татвар, нийгмийн даатгал суутгаагүй, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, цалин, нийгмийн даатгал, татвар зөрүүтэй, шилэн дансны мэдээлэл хангалтгүй мэдээлсэн,

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэлд хийсэн аудитаар сөрөг дүгнэлт авсан нь нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана"- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Сахилгын хариуцлага оногдуулах албан албан шаардлага хүргүүлсэн

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитад хамрагдсан байгууллагы н нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Түлээ нүүрсний хөнгөлөлтөөс ХХОАТ 50.5 мянган төгрөгийг суутган тооцоогүй	1	50.5	1	50.5	-	-	-	-	-	-
	Ажилтнуудад 1,216.1 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон	1	1,216.1	1	1,216.1	-	-	-	-	-	-
	Жилээс дээш насжилттай 7,784.9 мянган төгрөгийн авлагын тооцоо нийлээгүй, НДШ авлагыг 5,150.5 мянган төгрөг, удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтны шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговор 3,940.8 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу,	1	16,876.2	-	-	-	1	16,876.2	-	-	-
Өглөгийг 135.1 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд илүү тайлагнасан	1	135.1	-	-	-	1	135.1	-	-	-	-

Есенбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Цалингийн зардал, нийгмийн даатгалд тайлагнасан цалингийн дүнгээс 4,134.4 мянган төгрөгөөр, Татварын хэлтэс, нийгмийн даатгалд тайлагнасан цалин 16,602.5 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	20,736.7	-	-	1	20,736.7	-	-	-
Няравын тайлан гаргаагүй, бараа материалын тайланд бичиг хэргийн зардал 450.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлыг 1,250.0 мянган төгрөгөөр шууд бичилтээр тайлагнасан.	1	1,700.0	-	-	1	1,700.0	-	-	-
Зарцуулалт тодорхойгүй, анхан шатны баримт хангалтгүй 24,674.0 мянган төгрөгөөр гүйлгээ хийсэн нь	1	24,674.0	-	-	1	24,674.0	-	-	-
Нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй 42,071.0 мянган төгрөг төгрөгийн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хийсэн гэх боловч тушаал, илтгэх хуудас, тооцоо бодсон баримтаар нотлогдохгүй	1	42,071.0	-	-	1	42,071.0	-	-	-
Багийн иргэдийн нийтийн хурлын даргалагч нарт 1,100.0 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон	1	1,100.0	-	-	1	1,100.0	-	-	-
Цалингийн зардлаас олон нийтийн цагдаагийн 7,607.2 мянган төгрөгийн цалин олгож зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан	1	7,607.2	-	-	1	7,607.2	-	-	-

Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал 15,120.0 мянган төгрөгийг олгохдоо тайлан, санхүүгийн баримтад үндэслээгүй	1	15,120.0	-	1	15,120.0	-	-	-
Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн орлогыг 1,096.2 мянган төгрөгөөр дутуу, нэмэлт санхүүжилтийн тайланд 90.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, санхүүжилтээс татан төвлөрүүлсэн 3,851.6 мянган төгрөгийг хасах дүнгээр тайлагнасан	1	5,037.6	-	1	5,037.6	-	-	-
Өмнөх онд төрийн аудитын байгууллагаас 8,829.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 60,157.0 мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 1 хүнд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн боловч шийдвэрийн биелэлт ирүүлээгүй, уг шийдвэрийг давтан гаргасан байна	1						1	
Тайлан онд 1-6 мөнгөн гүйлгээний журнал хөтлөөгүй 72,568.0 мянган төгрөгийн гүйлгээг шууд бичилт хийсэн	1	72,568.0	-	1	72,568.0	-	-	-
<b>Дүн</b>	<b>14</b>	<b>208,892.5</b>	<b>2</b>	<b>1,266.6</b>	<b>207,625.9</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Шилэн дансанд байршуулах 5 саяас дээш орлогын 169,488.4 мянган төгрөгийн гүйлгээ, 500.0 мянган төгрөгийн 1 тушаал шийдвэр, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – хөтөлбөр, зориулалт, санхүүгийн тайлан, хандив, тусламжийн орлого, төсвийн төсөл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл огт мэдээлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-
	Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 3,725.0 мянган төгрөгийн дутуу шивсэн	1	-	-	-	1	3,725.0	-	-	-	-
	<b>Нийт</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>3,725.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>